# Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: **Монгол Улсын Консерваторийн Үндэсний хөгжмийн мэргэжлийн сургууль**

Хөтөлбөрийн нэр: **ХӨГЖИМДӨХ УРЛАГ /Үндэсний/**

Индекс: **D021502**


Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Энхцэцэг, МУБИС

Гишүүд: Ш.Цогтгэрэл, ҮБХИС

Б.Даваажав, ШУТИС


Он сар өдөр: **2020.06.05**

**Агуулга**

**Товчилсон үгийн тайлбар ........................................................................ 4**

**I.Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц,төлөвлөлт ............................................ 5**

**II.Сургалтын хөтөлбөрийнтанилцуулга ........................................................ 6**

**III.Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт .................................................................... 7**

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт ................................................................ 7

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа ........................................................ 10

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл .................. 12

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт ............................ 16

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа ...................................... 19

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа ............................................................ 23

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт ................................................ 27

**IV. Шинжээчийн багийн ажиллах хуваарь ...................................................... 32**

**V. Уулзалтад оролцогчдын нэрс .................................................................... 32**

I. Багш нарын нэрс ........................................................................................ 33

II. Оюутнуудын нэрс ...................................................................................... 33

III. Ажил олгогчдын нэрс................................................................................ 34

IV. Төгсөгчдийн нэрс ...................................................................................... 34

**V.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал ....................... 35**

**YI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

**YII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

- БМИҮЗ Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл
- БСШУСЯ Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын яам
- ДБСБ Дээд боловсролын сургалтын байгууллага
- МУК Монгол Улсын Консерватори
- ХБК Хөгжим бүжгийн коллеж
- ТАЗ Төрийн албаны зөвлөл
- СнЗ Сайд нарын зөвлөл
- СХМС Сонгодог хөгжмийн мэргэжлийн сургууль
- ҮХМС Үндэсний хөгжмийн мэргэжлийн сургууль
- БЦМС Бүжиг, Циркийн мэргэжлийн сургууль
- ХУДС Хөгжмийн ухаан, Дуулаачийн сургууль
- СБЗГ Сургалтын бодлого зохицуулалтын газар
- СНҮА Санхүү нийтлэг үйлчилгээний алба
- ДХШҮА Дотоод хяналт үйлчилгээний алба
- УБМА Уран бүтээл, маркетингийн алба
- ЭШИА Эрдэм шинжилгээ инновацийн алба
- ГХТХА Гадаад харилцаа, төсөл хөтөлбөрийн алба
- БНМАУ Бүгд найрамдах Монгол ард улс
- ХБДС Хөгжим бүжгийн дунд сургууль
- СУИС Соёл урлагийн их сургууль
- МТХТ Мэргэжлийн төгөлдөр хуурын тэнхим
- УХТ Утсан хөгжмийн тэнхим
- ҮЦХТ Үлээвэр хөгжмийн тэнхим
- ҮХТ Үндэсний хөгжмийн тэнхим
- ХУТ Хөгжмийн ухааны тэнхим
- ДТ Дуулаачийн тэнхэм
- СБТ Сонгодог бүжгийн тэнхим
- АБТ Ардын бүжгийн тэнхим
- ЦТ Циркийн тэнхим
- ЕЭТ Ерөнхий эрдмийн тэнхим...

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц,төлөвлөлт

| | | |
|---|---|---|
| **Сургуулийннэр /Монгол, Англи/** | Монгол Улсын Консерватори<br>Mongolian state conservatory | |
| **Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/** | Хөгжимдөх урлаг /Үндэсний/<br>Music performance /national | |
| **Индекс** | **D021502** | |
| **Шинжээчид** | Ахлагч: Д.Энхцэцэг- Монгол Улсын Боловсролын их сургуулийн Багшийн сургуулийн профессор, доктор<br>Гишүүд: Ш.Цогтгэрэл-Үндэсний Батлан Хамгаалах их Сургуулийн Цэргийн хөгжмийн сургуулийн багш, доктор<br>Б.Даваажав –Шинжлэх Ухаан Технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн профессор | |
| | Б.Мядагмаа – БМИҮЗ-ийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн | |
| **Төлөвлөгөө** | **Он сар өдөр** | **Хийгдсэн байх ажлууд**<br>Ажиллах хуваарийг хавсаргав |
| | | |
| **Шалгуур шаардлага /журам/** | БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06-р сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”, “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ын дагуу ажиллав. | |

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Хөгжимдөх урлаг /үндэсний/ бакалаврын хөтөлбөр

**Сургалт явуулж ирсэн түүх, туршлага:**

БНМАУ-ын Ардын сайд нарын зөвлөлийн ерөнхий сайдын тушаалаар Ардын гэгээрүүлэх яамны харъяа театрын дэргэдэх "Уран сайхны сургууль"-ийг 1937 оны 10- сарын 1-нд Чойжин ламын музейн зүүн талд байгуулжээ. Уран сайхны сургуулийн анхны төгсөгч нь ТШ, АЖ алдарт морин хуурч Г.Жамьян, СТА алдарт хуурч П.Буян нар байсан бол, УГЖ алдарт лимбэч, шудрагач "Үхэрчин хүү" хэмээн алдаршсан Л.Цэрэндорж, Д.Түдэв, С.Түвдэн, солгой Баяр, Д.Ишдулам, Ө.Лувсан, О.Дашдэлэг нар анхны багшаар нь ажиллаж байжээ.

1945оны 6-р сарын 1-нд БНМАУ-ын Сайд нарын зөвлөл, МАХН-ын ТХ-ны 34/30тоот тогтоол гарч Улсын төв театрын дэргэдэх "Хөгжимт драматик сургууль" /1945-1957/, 1957оны 9-р сарын 1-нээс ХБДС, 1992-1993 оны хичээлийн жилээс "Хөгжмийн коллеж", 1994 онд /7.20/ ХБСургууль, 1996 оноос /11.16/ ХБКоллеж болсон.

2002 оноос "Хөгжимдөх урлаг" хөтөлбөр /индекс D 021502/ -өөр Бакалавртай мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн. Эрх зүйн хувьд дараах хууль, тушаалаар зохицуулагддаг. Үүнд:

- Монгол улсад мөрдөж байгаа Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль
- БСШУЯ-ны сайдын 2014 оны 03-р сарын 13ны өдрийн "Мэргэжлийн индекс шинэчлэн батлах тухай " А/78 тоот тушаал
- Боловсрол шинжлэх ухааны сайдын 2014 оны 04-р сарын 28-ны өдрийн "Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага" А/174 тоот тушаал
- МУК-ийн эрдмийн зөвлөлөөр 2018 оны 11-р сарын 18-ны өдөр хэлэлцэж баталсан "Монгол Улсын Консерваторийн бакалаврын сургалтын журам" МУК-ийн захирлын А/107 тоот тушаал

**Хөтөлбөрийн тодорхойлолт:**

Хөгжимдөх урлаг хөтөлбөр нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар эзэмшүүлж, мэргэжлийн үнэт чанарыг төлөвшүүлэхэд чиглэнэ.

Хөгжимдөх урлагийн бакалаврын мэргэжил эзэмшсэн мэргэжилтнийг олон улсын нийтлэг жишиг, боловсролын стандартын дагуу бэлтгэнэ.

**Хөтөлбөрийн зорилго:**

Үндэсний хөгжмийн чиглэлээр мэргэшсэн, гадаад хэлний зохих мэдлэгтэй, эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу монгол улсын аль ч шатны урлагийн байгууллага, төрийн байгууллага болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн улсын болон хувийн хэвшлүүдэд хөдөлмөр эрхлэх мөн зохих шаардлагын дагуу сургалтын болон судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагад ажиллах чадвартай мэргэжилтэн бэлтгэх юм.

**Хөтөлбөрийн онцлог:**

Хөгжимдөх урлаг /үндэсний/ D021502 хөтөлбөр нь 10 төрөл хөгжмөөр суралцагчийн эзэмшвэл зохих цогц чадвар бүхий хөгжимчнийг бэлтгэн гаргадаг.

- Үндэсний үлээвэр хөгжим /Лимбэ, Баялаг бишгүүр, Ардын бишгүүр, Эвэр бүрээ/
- Үндэсний товшвор хөгжим /Ёочин, Шанз, Ятга/
- Үндэсний нумт хөгжим /Морин хуур, Хуучир, Их хуур/ хөгжмүүдээр нийт 22 үндсэн, 4 профессор, 1 зөвлөх , цагийн 7 багш ажиллаж, уламжлалт дэг сургалтыг тэнхимийн шаталсан сургалттай хослуулан сургалтыг явуулж байна.

Хөгжимдөх урлаг /үндэсний хөгжим/ хөтөлбөрөөр суралцахаар элсэгч нь

1. Шаталсан сургалттай үндсэн элсэгч буюу МУК-ийн мэргэжлийн сургуулийг дүүргэсэн / Мэргэжлийн дипломтой/
2. Ерөнхий боловсролын сургуулийн 12 анги төгссөн хөгжмийн зохих мэдлэг эзэмшсэн, цаашид өөрийгөө мэргэжлийн урлагийн салбарт хөгжүүлэх хүсэл тэмүүлэлтэй хүмүүсийг тодорхой шалгуураар элсүүлэн авдаг.

Хөтөлбөрөөр суралцагч нь нийт 129 кредит цагийг бүрэн судалж бакалаврын зэрэгтэй төгсөнө. Тухайн хөтөлбөрөөр суралцаж төгссөн мэргэжилтнүүд нь Урлаг судлал, хөгжим судлалын онол арга зүйн суурь мэдлэгтэй, Монголчуудын үндэсний урлагийн бүтээл туурвилын үнэт зүйлс, уран сайхны сэтгэлгээний хөгжлийг танин мэдэж тэдгээрийн талаар өргөн мэдлэг эзэмшинэ. Мөн урлаг судлал, хөгжмийн ухааны онол арга зүйн мэдлэгийг практикт ашиглан хөгжмийн зохиол бүтээлийг бие даан боловсруулалт хийн мэргэжлийн өндөр түвшинд хөгжимдөх ур чадвар эзэмшинэ. Үүний зэрэгцээ харилцааны болон багаар ажиллах ур чадвартай, Үндэсний ёс заншил, өв уламжлалаа дээдэлдэг, мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүйг баримталдаг, бие даан ажиллах, өөрийгөө хөгжүүлж, манлайлах хандлагатай болно.

## III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

**1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**
Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

**Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан, хавсралт, нотлох баримтууд
- Төгсөгчийн /мэргэжилтний/ загварыг тэдний эзэмших мэдлэг, чадвар, хандлага байдлаар тодорхойлсон байна.

- Гадаадын салбар болох төгсгөж буй мэргэжилтний хувьд ижил БНХАУ-ын ӨМӨЗО-ны Урлагийн Их сургууль, Казакстан улсын Казахская национальная консерватория-ийн “Традиционное музыкальное искусство” хөтөлбөрүүдтэй тус тус харьцуулан судалсан байна.
- Дотооддоо СУИС-ийн ижил индекстэй хөтөлбөрүүдтэй тус тус харьцуулан судалсан байна.
- Ажлын байрны хэрэгцээний судалгаа, судалгааны дүгнэлт
- Ажиллаж буй багш нар, ажил олгогч нар, төгсөгчидтэй хийсэн фокус ярилцлагууд

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- “Хөгжимдөх урлаг”-ийн мэргэжилтэнг 89 жил тасралтгүй бэлтгэж ирсэн туршлагатай.
- Өөрийн хөтөлбөрийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Урлагийн Их сургууль, Казакстан улсын Казахская национальная консерватория-ийн “Традиционное музыкальное искусство” хөтөлбөрүүдтэй тус тус харьцуулан судалсан байна.
- Ажлын байрны хэрэгцээний судалгаа, судалгааны дүгнэлт

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн хөгжүүлэлтэд оролцогч талуудын оролцоог сайн тусгах
- Сургалтын төлөвлөгөөндөө ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэших хичээлүүдийн лекц, семинар, дадлага, лабораторийн кредитийн харьцааг тодорхой болгох

**Зөвлөмж:**

- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан Хичээл тус бүрийн ерөнхий кредит нь лекц, семинар, дадлага, лабораторийн кредитүүдэд хэрхэн задарч буйг тодорхой харуулах шаардлагатай байна.

**1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан, хавсралт, нотлох баримтууд
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем тогтсон байна.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал

- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал
- Хөтөлбөрийн зорилгоо тодорхойлохдоо төрөөс боловсролын талаар баримтлах шинэчлэлийн бодлогууд, БСШУЯ-ы сайдын тушаал, МУК-ийн удирдах зөвлөлийн холбогдох тогтоолуудыг үндэслэсэн
- Сургалтын хөтөлбөрийн талаарх оюутан, төгсөгч, ажил олгогчдоос /нийт 120/ судалгаа авсан.
- Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн судалгаа сүүлийн 4 жилээр хийгдсэн байна.
- Ажиллаж буй багш нар, ажил олгогч нар, төгсөгчидтэй хийсэн фокус ярилцлагууд

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний системтэй байна.

**Анхаарах асуудал:**

- Төгсөгчдийн “бие хүний чадвар” хөгжүүлэхэд анхаарах

**1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**
Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан, хавсралт, нотлох баримтууд
- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал
- Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал
- Батлагдсан хичээлийн хөтөлбөрүүд

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байна.
- Хөтөлбөрийн төлөвлөлтдөө SWOT, TOWS шинжилгээ хийсэн байна

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн 13 зорилт /хуудас27-28/-ыг тодорхой бичиж тайланд хавсаргах

- Хөтөлбөрийн зорилт (PLO-85) ба хичээлүүдийн хөтөлбөрийн зорилт (CLO-191)-уудын хамаарлын матриц /хуудас 26/-ыг тайланд хавсаргах
- 2016, 2019 онуудад Сургалтын нэгдсэн төлөвлөгөөг өөрчлөхдөө ямар судалгаан дээр үндэслэгдсэнийг хавсралтад оруулах

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн зорилт (PLO)-ууд ба хичээл бүрийн зорилт (CLO)-уудын хоорондын хамаарлын матриц хийх
- Хичээлийн хөтөлбөрүүдийг хөтөлбөрийн дэд, салбар болон ерөнхий хороогоор оруулж баталгаажуулах

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

**Илрэл нотолгоо:**

• Хөгжмийн урлагийн дээд боловсролын үйлчилгээг 208 багш, 247 оюутанд 129 багц хичээлийг заан, сурган хүмүүжүүлж байна.

• Сургалтын үйл ажиллагаанд, удирдлагын мэдээллийн систем (X-CLOUD)-ийг бүтээлчээр хэрэгжүүлж байгаа нь сайн, давуу талыг харуулж байна.

• 2015-2020 оны хичээлийн жилд, хичээлийн хөтөлбөрийг зохиол бүтээл 209 ш, ардын дуу 66 ш, дасгал этъюд143 ш урын сангаар баяжуулан хөгжүүлсэн суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд бодит, эерэг нөлөөг үзүүлжээ.

• Сургалтын үйл ажиллагаа чанартай, үр дүнтэй байгаа нь ажил олгогч, төгсөгч, суралцагчдын уулзалт, ярилцлагаас харагдаж байна.

• Мэргэжлийн дадлага ажлын нэгдмэл бүтэц, тогтолцооны сүлжээ бүрэлдэнтогтсон байна.

• Мэргэжлийн хичээлийн давтлагын нийт 30 өрөөний цаг ашиглалтын түвшин өндөр байна.

• Сургалтын үйл ажиллагаа чанартай, үр дүнтэй байгаа нь ажил олгогч, төгсөгч, суралцагчдын уулзалт, ярилцлагаас харагдаж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага**

• Шавь сургалттай, дэг сургуулийг уламжлуулан хөгжүүлж буй 83 жилийн түүхэн

замналын туршлагыг бусад их, дээд сургууль, олон нийтэд сурталчлан таниулахад оршино.

**Анхаарахасуудал:**

- Сургалтын төлөвлөгөө, суралцахуйн үрдүнгийн матриц, хичээл хоорондын залгамж холбоог нарийвчлан боловсруулах шаардлагатай.
- Удирдлагын мэдээллийн системийн (X-CLOUD) мэдээллийн санг үндэслэн сургалтын амжилт, чанарыг хичээлийн жилийн улирал бүрээр судлан, үнэлж дүгнэх хэрэгтэй.

**Зөвлөмж:**

- 2037 онд тус сургууль үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг угтан, нийт хүн амын дунд нийгэм, хүмүүнлэг, соён гэгээрүүлэх бүтээлч 100 ажлыг удирдан, зохион байгуулах.
- Хөгжмийн урлагийн зах зээлд, шилдэг уран бүтээлээр манлайлах.

**2.2 Сургалтын арга зүй**
Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтын уламжлалт арга зүй нь арвин баян, биет бус өв сантай. Сургалтын уламжлалт арга зүйг мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийн хэлбрээр /on-lain хичээл, DVD 260ш, Монгол пянз 140ш, Монгол CD 140ш, Гадаад CD 620ш, Аудио кассет 135ш, гадаад пянз 1486 ширхэг, Нийт 2781 ширхэг байна.
- Сургалтын үйл ажиллагаанд зохиогчийн эрхээр баталгаажсан 15 ш ном, сурах бичгийг ашиглаж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

• Сургалтын уламжлалт арга зүй нь үндэсний өвөрмөц онцлог, хэлбэрийг илэрхийлсэн, үнэт баялаг болох нь харагдаж байна.
• Орон нутаг, бүс нутаг, олон улс, тив, дэлхийд улс орны нэр алдрыг цуурайтуулсан, мэргэжлийн ур чадвартай төгсөгчдийн тоо, хувь жилээс жилд нэмэгдэж байна.

**Анхаарах асуудал:**

• Үндэсний хөгжмийн урлагийн сан хөмрөг, соёлын үнэт баялагийг гадаадын урлагийн уран бүтээлч, төлөөлөгч, байгууллагын “оюуны хулгай”-аас урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.

**Зөвлөмж:**
• Сургалтын уламжлалт арга зүйг, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийн хэлбрээр баяжуулан, хөгжүүлсэн оюуны бүтээлийг зохиогчийн эрх, лизенци, патентын гэрчилгээгээр баталгаажуулах.

**2.3 Суралцагчийн үнэлгээ**
Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**
• Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлдэг арга зүйн үндэс нь мэргэжлийн онцлог шинж, давуу талыг илэрхийлж байна.
• Суралцагчийн үнэлгээнд АВ эзлэх хувь 2015-2016 оны хичээлийн жилд 88,6 хувь байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд 94,6 хувь болж 6 хувиар өссөн нь тэдний сурлагын амжилт, чанар дээшилж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**
• Суралцагчдын чадварыг академик болон техникийн шаардлагаар үнэлж дүгнэх явцын шалгалт нь бодит шалгуур үзүүлэлт ажээ.
• Суралцагчдад, тайзан дээр хөгжимчны зөв, боловсон байдал, ёс зүй, үзэгчтэйгээ хандах хандлага, харьцах харилцаа, соёлыг төлөвшүүлэхэд машид чухалчилдаг байна.
**Анхаарах асуудал:**
• Х2.3.1. /Оюутны мэдлэг, чадвар, дадал, хандлагыг үнэлэх онооны бүтэц/-ийн шалгуур үзүүлэлтийг, үнэлгээний арга зүйн нэгдмэл бүтэц, тогтолцоогоор нэг мөр болгох хэрэгтэй. /41х/
**Зөвлөмж:**
- Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж, дүгнэдэг хөндлөнгийн үнэлгээний арга зүйн туршлагыг бусад их, дээд сургуулиас судлан, суралцах
- Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлдэг арга зүйн нэгдмэл бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай.

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

**3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лабортори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Монгол улсын консерватори нь багш нарын ажиллах, оюутан сурагчдын сурч боловсрох эрүүл, аюулгүй, хүртээмжтэй үйл ажиллагаа явуулах сургалтын таатай орчинг бүрдүүлэх зорилгоор хичээлийн үндсэн 2 байр, оюутны байр, цахим сургалтын бичлэгийн студи, урлаг заал-2, бүжгийн заал, хөгжмийн заал-3, лингафоны кабинет зэрэг дадлага, сургалт судалгааны бие даасан нэгжүүдийн үйл ажиллагааг сайжруулан үе шаттайгаар тохижилт үйлчилгээ хийж сурах, сургах үйл явцыг дэмжин ажиллаж байна.
- Оюутан сурагчдын сурах таатай орчинг бүрдүүлэх зорилгоор хичээлийн жилийн амралт бүрээр урсгал болон их засварын ажил хийж, мөн сургалтын тоног төхөөрөмжийн шинэчлэлийн санхүүжилтийг жил бүрийн төсөвт суулган тодорхой үр дүн гаргаж шийдвэрлэж иржээ.
- МУК нь хичээлийн байр, оюутны байрны орчин, материаллаг баазыг нэмэгдүүлэх, сурах, сургах нөхцөл боломжийг сайжруулах бодлого, зорилгын үүднээс БСШУЯ-ны их дээд сургуулийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө, санхүүжилтийг нэмэгдүүлэн ажиллаж, “Дээд боловсролын шинэчлэл” төслөөс төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн сургалтын материаллаг орчинг бүрдүүлэхэд ахиц дэвшил гарган ажиллаж байна.
- МУК-ийн 1 оюутанд ноогдох талбай, кабинетын нэг суудалд ноогдох талбай, ээлжийн ашиглалтын коэффициент, байранд амьдардаг 1 оюутанд ноогдох талбай зэрэг нь дээд боловсролын байгууллагад тавигдах шаардлагын үзүүлэлттэй харьцуулахад “хэвийн” гэсэн дүгнэлт гарсан байна. Мөн нэг танхимд байх оюутны тоо стандарт хэмжээнээс бага буюу анги дүүргэлт хэтрээгүй байна.
- “Хөгжимдөх урлаг” хөтөлбөрөөр суралцагчдын сурах орчинг сайжруулах үүднээс “Нэрэмжит танхим”-уудыг байгуулжээ. Тодруулбал, “Хуучир, шударга, ёочин, лимбэ, морин хуур” хөгжмийн хичээлүүдийг тус сургуульд анх зааж байсан багш нарын ар гэрийнхэн, үр хүүхдүүдтэй хамтран ганцаарчилсан хичээлийн 45, 29, 46, 23, 34, 43 тоот танхимуудыг нийт 35.205.500₮-өөр тохижуулахын зэрэгцээ телевизор,

компьютор, магнитофон, пянз толуулагч, CD, DVD зэрэг сургалтанд ашиглах материаллаг зүйлсийг бүрдүүлжээ.
- МУК 120 суралцагч хүлээж авах боломжтой дотуур байртай. Нэг өрөөнд 4 суралцагч амьдрах ба халуун усны болон ариун цэврийн өрөө, номын сан, үзвэрийн өрөө, тэдгээрт шаардлагатай тавилга, эд хогшил, галын аюулгүй байдлыг хангах багаж хэрэгсэл, ослын гарц, давхар бүрийн камержуулалт зэргээр тохижилт хийж оюутнуудын тав тух, эрүүл аюулгүй байдал, амжилттай суралцах нөхцөл бололцоог бүрдүүлдэг байна.
- Үндэсний хөгжмийн тэнхимийн сургалтад ашиглагдаж байгаа сурах бичиг, гарын авлага, эмхэтгэлүүдийн ихэнх хувийг өнөөдөр ажиллаж байгаа багш нар боловсруулан гаргасан нь сайшаалтай.

**Анхаарах асуудал:**

- Хичээлийн II байр 1960 онд, оюутны дотуур байр 1970 онд ашиглалтад орсон бөгөөд энэ барилгын насжилтын хувьд онцгойлон анхаарах асуудал болсон байна. Эдгээр барилгад иж бүрэн засвар хийгдээгүй, зөвхөн урсгал засвар л хийгдэж ирсэн байна.
- “Хөгжимдөх урлаг” бакалаврын хөтөлбөрт суралцагчдад буюу энэ хөтөлбөрөөр сургалт явуулж байгаа багш нарт ноогдох компьютерийн тоо 7 байгаа нь хангалтгүй гэж үзлээ.
- Давтлагын өрөөний тохижилтод анхаарч агааржуулалт, гэрэлтүүлгийг сайжруулан стандарт-д нийцсэн сандалтай болгох. /Жич:Анхаарах асуудалд зөвхөн оюутнуудын хэлсэн саналыг бичив/
- Цайны газрын үйл ажиллагааг сайжруулж, хоолны порц, амт чанарыг дээшлүүлэхэд анхаарах

**Зөвлөмж:**

- Хичээлийн байрны насжилт болон аюулгүй байдлыг хангах хэвийн түвшинд байгаа эсэх талаар барилгын болон инженерийн мэргэжлийн байгууллага, нийслэлийн хот төлөвлөлтийн газар, улсын мэргэжлийн хяналтын газрын барилгын асуудал эрхэлсэн улсын байцаагч нарт албан хүсэлт гарган, тэд нараар шинжээчийн дүгнэлт гаргуулах зайлшгүй шаардлагатай. Улмаар улсын төсөвт хичээлийн байрыг шинээр бариулах, эсвэл хүчитгэл хийлгэх асуудлыг нэн даруй дэвшүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй.

### 3.2 Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- “Хөгжимдөх урлаг” хөтөлбөрөөр суралцагчид нь мэргэжлийн хичээлийн хамгийн чухал хэрэглэгдэхүүн болох “хөгжмийн зэмсгийг” худалдан авч өдөр тутмын сургалтандаа ашиглаж байгаа нь сургалтын чанар, технологийг дээшлүүлэх ололттой тал гэж үзлээ. Энэ нь сургалтын орчны тоноглолын талаар оюутан сурагчдаас авсан судалгааны дүнгээс ч харагдаж байна.
- Сургалт судалгааны SPSS, FINAL, Sibelius 6, 7, 8 нот бичлэгийн программ... гэх мэт нийт 20 гаруй сүүлийн үеийн программуудыг заримыг нь хөтөлбөрт туссан бүх хичээлд заримыг нь тодорхой шаардлагатай хичээлд, улмаар цахим хэрэглэгдэхүүн боловсруулах болон онлайн сургалтын арга зүйг сайжруулах зорилгоор ашигладаг байна
- Сургуулийн сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмжийн талаар 123 оюутнаас сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэлт гарган ажиллаж байна.
- Сүүлийн 5 жилд хөгжим сонсох, ноот гарын авлагын хүртээмж, хэрэглээ сайжирсан.
- Үндэсний хөгжмийн мэргэжлийн сургуулийн “Хөгжимдөх урлаг” хөтөлбөрөөр суралцагчид нь шаардлагатай үедээ CD, DVD бичлэгүүд пянз зэргийг сургуулийн сан хөмрөгөөс чөлөөтэй ашиглах боломжтой байна. Мөн удирдлага мэдээллийн нэгдсэн систем, Е-контент бэлтгэгдэж байна

**Анхаарах асуудал:**

- Оюутны сэтгэл ханамжийн судалгаагаар давтлагын өрөөний төгөлдөр хуурыг нэмж сайжруулах, компьютер техник хангамжийг нэмэгдүүлж сайжруулах шаарадлагатай гэж судалгаанд оролцогсдын 50-иас дээш хувь санал өгсөн байгааг цаашид анхаарч, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг шинэчлэх тал дээр анхаарах нь зүйтэй.

### 3.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа.

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- МУК-ийн номын сан нь 16900 төрлийн 36085 номын фондтой бөгөөд мэргэжлийн ном, сурах бичгийн хангамж, хүртээмжийг дээшлүүлэх талаар үе шаттай арга хэмжээ авч ажиллаж байна. Мөн багш оюутнуудаас хэрэгцээт ном, сурах бичгийн судалгааг тогтмол авч номын фондын баяжилтыг жил бүр хийдэг байна. Энэ нь номын фондын баяжилтын талаарх сүүлийн 5 жилийн график үзүүлэлтээс харагдаж байна.
- Номын сангийн “MONKOHA” цогц программыг 2019 оноос эхлэн сургалтанд нэвтрүүлж багш, оюутнууд интернэт орчинд чөлөөтэй ашиглах боломжийг бүрдүүлжээ. Мөн католог зохион байгуулах, уншигчийн цахим карт нээх, ном олгох, буцаалт зэрэг үйлчилгээний мэдээ, мэдээлэл гаргах зэрэг үйл ажиллагаа нь нэгдсэн нэг системээр явагдах болсон байна.
- Улсын төв номын сантай гэрээ байгуулж хамтран ажиллах болсноор тус номын сангийн мэдээллийн санд нэвтрэх боломж бүрджээ.

**Анхаарах асуудал:**

- Цаашид номын сангийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагын үүднээс номын санчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх зорилгоор сургалтад тогтмол хамруулж байх.
- Ном хэвлэл болон номын санд ашиглагдах техник хэрэгсэл материаллаг баазыг нэмэгдүүлэх /канон, скайнер, принтер гэх мэт/- д зориулсан зардлыг төсөвлөх, төсөвлөсөн хэмжээнд шаардлагатай мэргэжлийн ном, сурах бичиг, хэвлэл, техник хэрэгслийг худалдан авах

**Зөвлөмж:**

- Номын сангийн үйлчилгээний талаар судалгаанд оролцсон 124 хүний 50-иас илүү хувь нь номын сангийн орчинг сайжруулах, агааржуулалт сайтай байх, ширээ сандлыг шинэчлэх, дуу чимээг багасгах, хэрэгцээтэй шинэ гарсан номыг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн байгааг анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

**4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**
Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

• Тус сургуулийн захирлын тушаалаар хөтөлбөрийн дэд хороог байгуулан, ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд тус дэд хороо болон тэнхмийн хурлыг 27 удаа зохион байгуулж, хөтөлбөртөй холбоотой 12 асуудлыг шийдвэрлэжээ.
• Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой 8 эрхзүйн баримт бичгийг /тушаал, дүрэм, журам гм/ баримтлан, ажиллаж байна.
• Хөтөлбөрийн талаар суралцагчдаас санал хүсэлт, гомдол ирээгүй болно.

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан.**

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжийн богино, дунд, урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнана.
- Хөтөлбөрийн талаар ажил олгогч, суралцагчын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэсэн тухай ВЕb хуудсаар мэдээллэнэ.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд оролцогч, сонирхогч талуудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх менежментийн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх
- Хөтөлбөрийн ерөнхий болон салбар хороодын үйл ажиллагааг тогтмолжуулах. Хөтөлбөрийг профессорын баг баталгаажуулахгүй харин хөтөлбөрийн ерөнхий хороо эцсийн дүгнэлтийг өгөх шаардлагатай

**4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**
Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**
• Энэ хичээлийн жилд хэрэгжүүлж буй хамтарсан төсөл 1 ш, хамтарсан төслийн тайлан 1 ш, хамтын ажиллагааны 20 гэрээг хэрэгжүүлэн ажиллаж байна.
• Тэтгэлэгт хөтөлбөрт нийт оюутны 46 хувь нь хамрагдаж байна.
2014-2019 онд зохион байгуулсан, нийгэмд үзүүлсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд нийт 17050 үзэгч оролцсон бол давхардсан тоогоор багш 70, суралцагч 721 тус тус хамрагдагсан.
• Сургууль төгсөгчдийн холбоо нь үндэсний хөгжимчдийн мэргэжлийн холбоо, нийгэмлэг, зөвлөлтэй хамтран, нийгэм хүмүүнлэгийн, соён гэгэрүүлэх үйл ажиллагааг олон нийтийн дунд удирдан зохион байгуулж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

**Онцлог зүйл/Туршлага:**
• Төрийн хүндэтгэл, түүхт ойн баярын тоглолт, улсын уралдаан, багш, шавийн хамтын уран бүтээл, нийгэмд тустай ажил, сайн үйлсийн хандивын аян, өдөрлөг гм

хамтын ажиллагааны олон талт хэлбэр нь олон нийтийг соён гэгээрүүлэх үйлсэд бодит хувь нэмэр оруулж байна.

**Анхаарах асуудал:**

• Сургууль төгсөгчдийн мэргэжил дээшлүүлэх давтан сургалтыг тогтмолжуулах явдал юм.

**Зөвлөмж:**

- Хот, хөдөөгийн урлагийн авъяастай хүүхдийг судлах, танин мэдэх, тус сургуульд элсүүлэн суралцуулах, чадваржуулах, ажлын байраар ханган, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар орон нутгийн удирдлага, сургуулийн захирал, төгсөгчдийн хамтын үр дүн, урамшууллын гэрээ байгуулан, ажиллаж хэрэгжүүлнэ.

**4.3 Санхүүжилт**
Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

**Илрэл нотолгоо:**

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зардал нь сүүлийн 5 жилийн дунджаар 31,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
-Нэг суралцагчид ногдох өртөг нь сүүлийн 5 жилийн дунджаар 14,7 хувиар өсжээ.
-Төр, хувийн хэвшлийн санхүүгийн дэмжлэг нь сүүлийн 5 жилийн дунджаар нийт зардлын 0,9 хувийг
эзэлж байна.

**Онцлог зүйл/Туршлага:**

- Төсвөөс бүрэн санхүүждэг

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан.**

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг багш, суралцагчийн хөгжилд зарцуулахад онцгойлон анхаарахдаа санхүүгийн төлөвлөлт, төсвийг хөтөлбөр хөгжүүлэхэд төлөвлөж, зарцуулах

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн санхүүжилтийг олон эх үүсвэрээс нэмэгдүүлэх менежмент, бизнесийн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх.
- Хөтөлбөрийн төсөв, санхүүгийн зорилго, санхүүжих механизмыг төлөвлөлт бодлого боловсруулан ажиллах

**4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**
Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- “Уран бүтээл, маркетингийн алба” нь тус хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийн ажлыг холбогдох салбар, нэгжтэй хамтран зохион байгуулдаг

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, ажиллах

**Зөвлөмж:**

- Тус хөтөлбөрөөр элсэн суралцагчдад зориулан мэргэжил сурталчлах өдөрлөг,аяныг жил бүр зохион байгуулж, хэвшүүлэх
